



ГАРЧИГ

50 ЖИЛИЙН ОЙН КАМПАНИТ АЖИЛ
 ЦААЗААР АВАХ ЯЛЫГ ХАЛАХ КАМПАНИТ АЖИЛ
 ХҮНИЙГ ХҮНДЭЛ КАМПАНИТ АЖИЛ
 УЛС ОРНУУДЫН ТӨЛӨӨХ КАМПАНИТ АЖИЛ
 ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КАМПАНИТ АЖИЛ
 ЗАЛУУЧУУДЫН КАМПАНИТ АЖИЛ
 ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ
 БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ
 2011 ОНД ХЭВЛЭСЭН НОМ, ТОВХИМОЛ
 САНХҮҮГИЙН ТАЙЛАН



ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

Бид Монголын Эмнести Интернэшнлийнхэн. Бид байнга хэцүү асуулт тавьдаг. Бас дандаа илүү ихийг..... илүү их шударга ёс, илүү их хүндлэл, илүү их эрх, эрх чөлөөг хүсдэг.

Бид энэ жил 50 жилийн ойгоо илүү чанга, тодоор дуу хоолойгоо илэрхийлж, хэзээ хэзээнээсээ илүү цөхрөлтгүйгээр тэмцэж тэмдэглэлээ.



УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Р. Янжмаа	Удирдах зөвлөлийн дарга
М. Чимиддорж	Удирдах зөвлөлийн дэд дарга
А. Отгончимэг	Санхүүч
С. Ганчимэг	Хүний эрхийн боловсрол хариуцсан гишүүн
Л. Нэргүй	Бүлэг, гишүүнчлэл хариуцсан гишүүн
Д. Оюунсүрэн	Кампанит ажил хариуцсан гишүүн
Д. Оюунномин	Хэвлэл мэдээлэл хариуцсан гишүүн
Я. Мөнхчимэг	Сан арвижуулалт хариуцсан гишүүн
Т. Төртогтох	Залуучууд хариуцсан гишүүн



ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

Б. Мөнхжавхлан	Хяналтын зөвлөлийн дарга
Л. Галбаатар	Хяналтын зөвлөлийн гишүүн
М. Адьяаням	Хяналтын зөвлөлийн гишүүн



ГҮЙЦЭТГЭХ ТОВЧОО

Б. Алтантуяа	Гүйцэтгэх захирал
П. Мөнхжаргал	Хөгжил, гишүүнчлэл хариуцсан зохицуулагч
Г. Амарзаяа	Кампанит ажил хариуцсан зохицуулагч
Л. Анх-Оюун	Кампанит ажил хариуцсан зохицуулагч
Т. Ариунаа	Санхүүгийн ажилтан
Б. Аззаяа	Хөгжил, гишүүнчлэл хариуцсан зохицуулагч
Жоанна Луис	Залуучууд хариуцсан зохицуулагч
Шарон Со	Хүний эрхийн боловсрол, Сан арвижуулалт хариуцсан зохицуулагч
С.Очирбат	Гэрээт ажилтан



ДАДЛАГЫН БОЛОН САЙН ДУРЫН АЖИЛТНУУД

М.Өлзийбүрэн	Б.Боргилчулуун	Г.Гантулга
М.Нандинцэцэг	Н.Бүрэнжаргал	Б.Билгүүн
М.Отгонгэрэл	Б.Түвшингоо	Т.Энхжаргал
Х.Солонго		

50 жилийн ойн кампанит ажил

Зорилго, зорилтууд

- ЭИ-ийг өргөн хүрээнд танилцуулж, гишүүд дэмжигчдийг идэвхижүүлэх, уриалах

Шударга ёс, хүний эрхийн төлөө хагас зууны туршид хүний эрхийг хамгаалагчид хамтдаа тэмцэж байна. Дэлхий ертөнцийг өөрчлөхөд хүн бүрийн оролцоо маш чухал юм.

Хошин жин

- 2011 оны 5-р сарын 28-ны өдөр Дархан, Эрдэнэт, Багануур, Улаанбаатар хотод “Хүний эрхийн төлөө 50 жил” ойн арга хэмжээг нэгэн зэрэг зохион байгуулж, хүний эрхийг хамгаалагчдын даян дэлхийн хөдөлгөөний гүндэсний хэмжээнд давалгаалуулан Монголын дугуйчдын холбооны 50 дугуйчид хотоор аялан Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэн дээр “Эрхийнхээ төлөө нэгдэцгээе” үзүүлбэр, Хүний эрхэд ээлтэй сургууль – Монгол Энэтхэгийн Хамтарсан Сургуулийн авьяаслаг зохион бүтээгч сурагчдын “Хүний эрхийн төлөө загварын шоу” үзүүлбэрийг 4500 гаруй хүмүүст хүргэсэн төдийгүй урлаг, спортын болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, олон нийтийг хүний эрхийн үйлсэд идэвхжүүлсэн арга хэмжээ болж өнгөрөв.
- Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнд “ХҮНИЙ ЭРХИЙН ТӨГӨЛ” байгуулагдлаа.

Даяар үйл ажиллагаа

- Нигер Делта дахь газрын тосны бохирдлыг арилгах, Никарагуа дахь охид эмэгтэйчүүдийн бэлгийн хүчирхийллийг зогсоох гээд дэлхийн бусад улс орнууд дахь зөрчлийн хэргүүд дээр ажиллах уриалга гаргаж гишүүдийнхээ дунд “Идэвхитэй бай Дахиад нэг хүнд хүргэ” аян өрнүүлж, 1500 гаруй гарын үсэг, 300 эрвээхэй зуруулан илгээлээ.
- Олон улсын хүний эрхийн өдрөөр эрсдэлд буй хувь хүмүүс, хүний эрхийн хамгаалагчдын төлөө “Гэрлээ асаая” үйл ажиллагаа зохион байгуулж, 5 хүний эрхийн хамгаалагчдын төлөө 5000 гарын үсэг цуглуулж, илгээлээ. Эмнести эрсдэлд буй хувь хүмүүсийн төлөө, хүний эрхийн 14 хамгаалагчдын үйлсийг гэрэлтүүлэн өмнөхөөсөө илүү их амжилтанд хүрлээ. Дэлхий даяар олон мянган хүмүүс захидал бичиж, уриалгад гарын үсгээ зурж, гар утасны мессеж илгээж, өөр бусад олон хэлбэрээр оролцлоо. Бид хамтдаа 83 оронд 1 сая захидал цуглууллаа.

Нөлөөллийн ажил

- Даян дэлхийн хөдөлгөөний амжилтын түүх, дэлхийн 50 тэмцэгчийн үйл хэргийн тухай өгүүлсэн номонд Монголоос иргэн Ц.Энхбаярын тэмцлийн түүх бичигдлээ.
- Хүний эрхийг дэмждэг урлагийн хүмүүсийн дэмжлэгтэйгээр уран зургийн галлерейд Эмнести дэлгүүр гаргаж, Дэлхий дахин дахь хүний эрхийн нөхцөл байдал тайлангийн хэвлэлийн бага хурал хийв.
- Юнител компанийн дэмжлэгтэйгээр 30,000 хэрэглэгчдэд нь “Эрхээ мэд, эрхээ шаард, эрхээ хамгаал” масс мессеж илгээлээ.
- 2009 оноос эхэлсэн “Таны үгийг сонсьё” аян үргэлжилж 9000 гаруй хүний санал бодлыг нэгтгэлээ. Бид ядуурлын талаархи иргэдийн санал бодлыг “Нэр төртэй амьдарцгаая” ном болгон эмхэтгэн гаргах болно.



Цаазаар авах ялыг халах кампанит ажил

Зорилго, зорилтууд

- Цаазаар авах ялыг халахад нөлөөлөх;
- Үр дүн нь хүний эрхэд чиглэсэн, харилцан ашигтай харилцааг бусадтай тогтоон, хамтрагчдын тоог нэмэгдүүлэх
- Үйл ажиллагаанд гишүүд, дэмжигчдийг өргөнөөр оролцуулах
- Улс орондоо явуулж буй ажлыг дэлхий нийтийн чиг хандлагатай нийцүүлэх
- Мэдээллийн технологи, ялангуяа харилцаа холбооны шинэ технологийг хэрэглэх

Түншилж ажилласан байгууллагууд:

Нээлттэй нийгэм хүрээлэн, JCI Монгол үндэсний байгууллага, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн Холбоо, Хэлмэгдэгсдийн музей, ХЭҮК, "Амьд явах эрхийг хамгаалах үндэсний нийгэмлэг" ТББ, АНУ-ын "Хүн амины гэмт хэргийн хохирогчид хүний эрхийн төлөө" ТББ, Цаазаар авах ялын Эсрэг Азийн Сүлжээ, "Нээлттэй Академи" ТББ, Парламентийн Шадар Туслахуудын Холбоо, "Тинк танк" студи

Нөлөөллийн ажлууд:

- Жил бүрийн 1-р сарын 14-ний өдрийг "Амьд явах эрхийг хамгаалах өдөр" болгон зарлах уриалга гарган хэвлэлийн бага хурал зохион байгуулж, төрийн 3 өндөрлөгт уриалгыг гардууллаа.
- "Цаазаар авах ял ба гүйцэтгэл 2010" судалгаа, "Ази тив дэх энэрэлгүй шударга бус явдал" тайланг танилцуулах хэвлэлийн бага хурлууд зохион байгуулав. Цаазаар авах ялыг хуульдаа болон практикт халсан ОХУ, Франц, Герман, Шинэ Зеландын хууль эрх зүйн орчинд судалгаа хийж "Цаазаар авах ялыг халах нь: зарим улсын туршлага" товхимол гаргав.
- МҮОНТ, С1 телевизээр "Хүний эрх - цаазын ял" сэдвээр ярилцлага хийлээ. МҮОНТ, бусад ТВ-ын сувгуудаар "Үхдэл явж байна" зэрэг уран сайхны кинонуудыг үзэгчдэд хүргэж, цаазаар авах ялтай холбоотой асуудал хөндөв.
- ЦАЯ-ын эсрэг Дэлхийн өдөр хэвлэлийн бага хурал, кино хэлэлцүүлэг, шүүгч, прокурор, өмгөөлөгчдөд зориулсан сургалт ярилцлага зэрэг цогц арга хэмжээ зохион байгуулав. ХЗС, Сэтгүүлч, Хууль зүйн сургуулиудын оюутан залуус болон иргэд өргөнөөр оролцов.
- 11 сарын 30-нд "Амьдралын төлөөх хотууд" Дэлхийн өдрийг тэмдэглэж, "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалын музейд хэлэлцүүлэг уулзалт хийв. Хэлмэгсдийн музейг гэрлээр чимэглэн хүний амьд явах эрхийг дэмжин гэрэлтүүлээ. Энэ өдөр Их дээд сургуулийн түүхийн ангийн оюутнууд, дунд сургуулийн сурагч, олон нийт музейг үнэгүй үзэж сонирхлоо.
- Цаазаар авах ялыг халах үндэслэл", НҮБ-ын тогтоол, "Хүн бүр амьд явах эрхтэй" плакат, "Цаазаар авах ялыг халах нь: зарим улсын туршлага", Цаазаар авах ял ба гүйцэтгэл 2010", "Ази тив дэх энэрэлгүй шударга бус явдал", "Шударга ёс алдагдвал" зэрэг судалгааны тайланг хэвлүүлэн, олон нийт, холбогдох хүмүүст хүргэлээ.

Кино хэлэлцүүлэг, сургалт, уулзалт


- Дархан, Ховд, Увс, Хэнтий аймгийн иргэд, Улаангом коллеж, Хөдөлмөрийн дээд сургууль, УБ хотод Отгонтэнгэр, Удирдлагын Академийн сонсогч, багш нарт, МУИС-ийн ЭЗС, Газарзүйн сургууль, НШУС-ийн оюутнуудад "Хүний эрх ба цаазаар авах ял" сэдэвт кино хэлэлцүүлгийг зохион байгууллаа.
- "Хөгжил ба хүний эрхэд суурилсан хандлага- Амьд явах эрх" сэдвээр УИХ-ын гишүүдийн туслахуудад сургалт хийв.
- ХЭҮК, НҮБ-ын суурин төлөөлөгч, Евро парламентийн гишүүд, МАН-ын бүлгийн ахлагч, парламентийн зарим гишүүнтэй уулзж Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Нэмэлт II Протоколд Монгол улс нэгдэж орох асуудлыг дэмжихийг уриаллаа.

Захидал уриалга, Цахим ажиллагаа

- Эмнести Интернэшнлийн Өмнөд Солонгос, Австри, Швед, Норвег зэрэг бусад секц, МЭИ-ийн гишүүд, дэмжигчид УИХ-ын гишүүдэд хандан ЦАЯ-ыг халах, ИУТЭОУП-ын Нэмэлт II Протоколд нэгдэн орохыг уриалсан захидлыг илгээлээ.
- Иран улсыг насанд хүрээгүй хүмүүсийг цаазлахаа зогсоохыг шаардсан, АНУ-д цаазаар авах ялыг халсан 16 дахь муж улс болсонд нь талархал илэрхийлсэн ил захидалд дэмжигчдийн гарын үсгийг цуглуулж Иллиной мужийн амбан захирагчид тус тус илгээлээ.
- Монгол, Беларусь дахь цаазаар авах ялыг халах уриалгад онлайнгаар гарын үсэг зурах үйл ажиллагааг гишүүдийнхээ дунд өрнүүлээ.

ГОЛ АМЖИЛТ, ҮР ДҮН

- 2-р Нэмэлт Протоколд нэгдэн орох асуудал УИХ-ын хаврын чуулганд өргөн баригдаж, Аюулгүй байдал, Гадаад бодлогын Байнгийн Хорооны хуралдаанаар 100%-ийн саналаар дэмжигдэв.
- Хамтарч ажиллах байгууллагууд нэмэгдэн, тэдгээр байгууллагатай байнгын харилцаатай ажиллаж байна.
- Цаазаар авах ялын асуудлаархи мэдээ, өгүүлэл, ярилцлага, хэлэлцүүлэг, мэтгэлцээн сонин хэвлэл, радио, ТВ, орон нутгийн сувгаар өргөн хүрээнд өрнөж давхардсан тоогоор 500 000 орчим хүнд хүрэв.
- УИХ-ын гишүүний 35 туслах, Нийслэл, дүүргийн хяналтын 53 прокурор, Эрүүгийн танхимын 38 шүүгч, 52 өмгөөлөгч сургалт, хэлэлцүүлэгт оролцов.
- Кино хэлэлцүүлэгт нийтдээ 1000 орчим хүн хамрагдав.



Эдийн засаг, нийгэм соёлын эрхийг хамгаалах (((Хүнийг хүндэл))) кампанит ажил

Зорилго, зорилтууд

- Ядуусын дуу хоолойг сонсгож, үр нөлөөтэй байлгахын төлөө эрх чөлөө нээлттэй ил тод байдал, эвлэлдэн нэгдэх эрх, мэдээ мэдээллээр хангах
- Эрх мэдэж, түүнийгээ нэхэмжлэх замаар ядуу нөхцөлд амьдарч буй ялангуяа уугуул иргэдийг чадавхижуулах, Төр болон төрийн бус оролцогчидыг хариуцлагатай болгох,
- Урьдчилан сэргийлж болохуйц эхийн эндэгдэлд Засгийн газрын анхаарлыг хандуулах
- Эрх эдлэгч болон идэвхитнүүдийн дэмжлэгийг өсгөх, олон нийтийн дунд хөдөлгөөний нэр хүндийг өсгөх

Дэлхийн улс орнуудын удирдагчид ядуурлыг бууруулах, эхийн эрүүл мэндийг хамгаалах, ядуусын хорооллын эрүүл ахуйг дээшлүүлж, цэвэр усны хангамжийг сайжруулахад чиглэгдсэн Мянганы хөгжлийн зорилтуудыг тодорхойлсон билээ. Мянганы тунхаглалаар ядуурлаас ангид байх нь хүний эрх гэж тогтоосон.

“Нэртэй амьдарцаа” захидлын аян

- Ялгаварлан гадуурхагдаж ядуу нөхцөлд амьдарч буй эрэгтэйчүүдийн дуу хоолойг хүргэх, амьжиргаагаа дээшлүүлэхэд тэдний оролцоог хангах зорилгоор Монголын Эрэгтэйчүүдийн Хөгжлийн Нийгэмлэг, Монголын Эрэгтэйчүүдийн Холбоотой хамтран “Ядуурал ба эрэгтэйчүүд” аян өрнүүлээ.
- Олон улсын эрэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан НЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс, Халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэнүүдийг оролцуулан эрэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж, нийгмийн хамгаалал, халамжийн бодлого, хөдөлмөр эрхлэлт болон эрх зүйн туслацгаа авах үйлчилгээний хүртээмжид эрэгтэйчүүдийн асуудлаар төрийн болон иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоотой хамтарсан зөвлөмж боловсруулав.

Нөлөөллийн ажил

- Эрүүл мэндийн яамны Хүний эрхийг хангах салбар хороотой хамтарсан хүний эрхийн сургалт зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагын 30 эмч, эмнэлгийн ажилтанд “Хүний эрхийн сургагч багш” сертификат гардууллаа.
- Сургагч багш нар Хавдар судлалын үндэсний төв, Сэтгэц судлалын үндэсний төв, Нийслэлийн эрүүл мэндийн газар дээр сургалт хамтран зохион байгуулав.
- Монгол улс ЭЗНСЭОУП-ын Нэмэлт протоколыг соёрхон баталсантай



холбогдуулан тус протоколын 10, 11-р зүйлд заасан асуудлаар тунхаглал гаргах талаар тодорхой саналуудыг тусгасан захидлыг МУ-ын Ерөнхий сайд, болон ГХ-ны сайд нарт илгээж, уг асуудлаар хариу албан бичиг хүлээн авлаа.

- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлэхэд хоол хүнс, цэвэр ус, шаардлагад нийцсэн орон байраар хангагдах, эрүүл мэнд, сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгмийн халамж хамгаалал хүртэх эрхийг хангах замаар амьжиргааны чанарыг дээшлүүлэхийн тулд засгийн газраас эдгээр эрхийг үндэсний хууль тогтоомжид тусгайлан баталгаажуулах хэрэгтэй. Үүнтэй холбоотойгоор “Эрхээ хуульчильяа” гарын авлага гаргаж хэвлүүлэн сургалт, хэлэлцүүлэг уулзалтаар тараав.

Олон Улсын кампанит ажлууд

Шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийн хүрээнд Кений засгийн газрыг цэвэр усаар хангагдах эрхийг баталгаажуулах уриалга, Хүрч болох дээд түвшинд эрүүл байх эрх, эхийн эндэгдэлийн асуудлаарх Перу, Буркино Фасо, АНУ-ын засгийн газарт хандсан уриалга ил захидал, Энэтхэгийн Орисса муж дахь албадан нүүлгэхийг зогсоох талаар захидал уриалга, компанийн хариуцлагын асуудлаар Нигер Делта дахь газрын тосны бохирдлыг цэвэрлэх уриалга, Цэвэр усаар хангагдах эрхийн тухай Словений засгийн газарт хандсан ил захидал болон уриалгад оролцож, Никарагуа дахь охид эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, эв санааны нэгдлээ илэрхийлэн Эрвээхэй илгээх олон нийтийг хамарсан үйл ажиллагааг өрнүүлсэн.

Өөрийн оронд хийх судалгаа

Хот дахин төлөвлөлт, гэр хорооллын асуудлаар холбогдох мэргэжилтэнүүдтэй хамтран ажиллаж, Монгол улс дахь албадан нүүлгэн шилжүүлэлтийн хууль эрх зүй, зохицуулалтын орчны шинэчлэл төслийн хэлэлцүүлэгт оролцож, олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу газар чөлөөлөлт, нүүлгэн суурьшуулалт, нөхөн олговрын асуудлаар ОУНБДНГ-ын шинжээчдийн санал дүгнэлтийг гаргуулахаар ажиллаж байна.

ГОЛ АМЖИЛТ, ҮР ДҮН

- Таны бодлоор нэр төртэй амьдрах гэж юу вэ санал асуулгад 9,000 санал авав.
- Нигериа дахь Порт Харкорт дахь албадан нүүлгэлтийг зогсоож, 200,000 хүн албадан нүүлгэх эрсдэлтэй байсныг таслан зогсоож чадлаа. Монголоос 1900 гарын үсэг бүхий уриалга, захидал илгээж байсан юм.
- Нийт 25 байгууллагатай хамтарч, үйл ажиллагаанд 750 дэмжигч, 50 идэвхитэн оролцож, 6000 гаруй хүнд хүрч ажиллав.



Улс орнуудын төлөөх кампанит ажил

Зорилго, зорилтууд

- Эрсдэлд буй хувь хүн, Хүний эрхийн хамгаалагчдийг хамгаалах үйл ажиллагаагаа бэхжүүлэх, дэлхийн мэдээллийн гол төвүүдийн анхаарлыг татах;
- Шинээр үүсч буй эрсдэл, боломжуудад тооцоолсон хариу үйлдэл хийх чадамж бий болгох,

Түншилж ажилласан байгууллагууд

“Sky” худалдааны төв, Номин hypermarket, ШУТИС, МУИС, ЭЗС, МУИС-ийн ОУХС, ХААИС

Нөлөөллийн ажил:

- ОУТ-ийн Зүүн Ази хариуцсан Кампанит ажлын зохицуулагчийн хамт ХЭҮК, УЕПДМБА, МӨХ, ШШГЕГ, Дээд шүүх, Үйлдвэрчний эвлэл, Хүний эрх хөгжил төв, Иргэдийн Альянс, Сонгогчдын Боловсрол, Глоб Интернэшнл зэрэг төрийн болон ТББ-ууд, хувь хүн, иргэдтэй уулзалт хийв. Олон улсын төвийн шинжээчийн хамт шинээр баригдсан Цагдан хорих 461, Хорих 423-р ангиар айлчлан, нөхцөл байдалтай нь танилцав.
- “Хүний эрхийн нөхцөл байдал 2011 он” тайлан танилцуулах хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж, Төрийн болон ТББ, Олон улсын байгууллагуудыг урьж оролцуулав, Тайланг хүний эрхийн чиглэлээр ажилладаг байгууллага, хувь хүмүүс, иргэдэд тараан хүргэлээ.
- Өмнөд Солонгос дахь цагаач ажилчдын эрх” гарын авлагыг хэвлүүлэн иргэд, төрийн болон ТББ-ууд, мөн Өмнөд Солонгост ажиллаж буй монголчуудад тараав.
- “Шударга ёс, Шударга ёс” Хятадын Шинжаан Уйгарт болсон үймээний талаархи тайлан илтгэлийг орчуулан, хэвлэж тараав.

Цахим уриалга:

- Гишүүддээ “Идэвхтэй оролцоо ба цахим аян” сургалтыг зохион байгуулж, нэн тэргүүнд анхаарч ажиллах улс орнуудын судалгаанд оролцож, захидал уриалга бичих загварыг цахим хуудсанд байрлуулав.
- Нэн тэргүүнд анхаарч ажиллах улс орнуудын судалгаанд оролцож, захидал уриалга бичих загварыг цахим хуудсанд байрлуулав.

Сургалт, семинар:

- Чөлөөт бүлгээс Цагаач ажилчдын эрх сэдвээр оюутан залуучуудын дунд илтгэл мэтгэлцээн зохион байгуулав.
- МЭИ-ийн шинэ гишүүдийн болон бүх гишүүдийн уулзалтуудын үеэр Улс орнуудын төлөө кампанит ажлын танилцуулга хүргэж, чадавхи бэхжүүлэх сургалтыг зохион байгуулсан.
- Цагаач ажилчдын эрх сэдвээр Сэтгүүлчдийн бүлэгтэй хамтран ОУХС-ийн оюутнуудад сургалт зохион байгуулж, хэвлэлийн мэдээ хүргэсэн.
- Шинэ гишүүдэд зориулсан сургалт, бүх гишүүдийн уулзалтын үеэр болон Эмэгтэйчүүдийн нүдээр чуулга уулзалтанд гишүүдийг оролцуулж Никарагуа дахь охид эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлаар мэдээлэл хийж, тараах материал гарын авлагыг тараасан.

Олон улсын хүний эрхийн өдөр:

• Олон улсын хүний эрхийн өдөр буюу жил бүрийн 12-р сарын 10-ны өдөр Захидал Уриалгын Марафоныг МУИС-ын ЭЗС, ОУХС, ШУТИС, ХААИС зэрэг их дээд сургууль, Энэтхэг Монголын хамтарсан сургууль, Хобби дунд сургуулиуд, Тэнгис кинотеатр, Sky, Номин дэлгүүрүүдтэй хамтран зохион байгууллаа. Энэ үеэр Нигериа, Хойд Солонгос, Йемен, ОХУ, Шриланка улсад хүний эрх зөрчигдөж байгааг таслан зогсоохыг уриалсан захидлуудад 5000 орчим гарын үсэг цуглуулж илгээлээ.

Оролцсон бүлгүүд

Чөлөөт, Дархан, Эрдэнэт, Хуульч, Сэтгүүлч, Оюутан, Сурагч, Лобби, Урлаг, Эмэгтэйчүүд, ҮЭ, Залуучууд бүлэг

ГОЛ АМЖИЛТ, ҮР ДҮН

- Яаралтай үйл ажиллагааны бүлгийн үйл ажиллагаа идэвхжин, 3 удаагийн сургалтанд 30 гаруй гишүүн хамрагдав.
- Эрсдэлд буй 14 хүний эрхийн хамгаалагчийн төлөө захидал бичих аян өрнүүлж, Олон улсын хүний эрхийн өдрөөр Нигериа, Хойд Солонгос, Йемен, ОХУ, Шриланка дахь 5 хүний эрхийн хамгаалагчийн төлөө 5000 гаруй гарын үсэг цуглуулж дээрхи улсуудын эрх баригч нарт илгээв.



Эрүүдэн шүүхийн эсрэг кампанит ажил

Зорилго, зорилтууд

- Монгол улс ЭШЭКНП-д нэгдэн орж, тохиромжтой ҮҮСМ байгуулсан байх
- ҮҮСМ-ийн бие бүрэлдэхүүнүүд хорих газарт хийх мониторингийн талаар сургалтанд хамрагдсан байх
- Дэлхий нийтэд хянан шийдвэрлэх гэмт хэргийн харьяалалыг хүлээн зөвшөөрөх, ОУЭШ-тэй хамтын ажиллагаа бэхжсэн байх, дэмжин ажилласан байх

Нөлөөллийн ажил:

- Эрүүдэн шүүх гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал, зөвлөмжийг холбогдох байгууллага, ажлын хэсэгт хүргүүлээ.
- Хорих, цагдан хорих газарт хараат бус, хөндлөнгийн мониторинг хийх эрх бүхий Үндэсний Урьдчилан Сэргийлэх Механизм байгуулах, ЭШЭК-ийн Нэмэлт Протоколд нэгдэн орох асуудлаар ХЭҮК, Азийн Форум, Женевийн Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх нийгэмлэгтэй хамтран холбогдох төрийн байгууллагууд, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан дугуй ширээний уулзалт семинар зохион байгуулав.
- 11-р сард болсон ЭШЭК-ийн Нэмэлт Протоколын асуудлаарх Дэлхийн Форумд урилгаар оролцлоо. ЭШЭК-ийн Нэмэлт Протокол хүчин төгөлдөр үйлчилж эхэлсний таван жилийн ойг тохиолдуулан зохион байгуулагдсан энэ хуралд Протоколд нэгдэж орсон улсууд, Үндэсний Урьдчилан сэргийлэх Механизм, Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны төлөөлөгч, шинжээчид цугларч протоколын хэрэгжилт, үр нөлөө, учирч байгаа бэрхшээлүүдийг даван туулах аргыг тодорхойлох, тогтолцоог бэхжүүлэх асуудлаар санал солилцов.

Цахим уриалга, Сургалт, семинар:

- Эрүүдэн шүүхийн хохирогчдод туслах олон улсын өдөр буюу 6-р сарын 26-нд Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулж, Ерөнхий сайд, ХЗДХ-ийн сайдад хандсан захидалд гарын үсэг цуглуулж, ЭШЭКНП-д нэгдэн орохыг уриалав.



- 6-р сарын 30-нд Аполлон галерейд эрүүдэн шүүхтэй холбоотой зурагт хуудасны үзэсгэлэн гаргаж, нээлтэнд Франц улсын элчин сайд, УЕПДМБА-ны дарга, ХЭҮК, шашны төлөөлөл, хүний эрхийн ТББ-ууд, гишүүд дэмжигчид оролцов.
- Кампанит ажлын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, хэвлэлийн мэдээг өдөр тутмын сонинууд болон amnesty.mn вэб сайтаар дамжуулан олон нийтэд хүргэж, цахим уриалгад нэгдэв.
- АНУ-ын ерөнхийлөгч асан Жорж Буш Швейцарт хийх айлчлалаа цуцалсан тухай хэвлэлийн мэдээг орчуулан amnesty.mn вэб сайтад байрлууллаа.
- Хорих газарт дахин мониторинг хийх, жишиг хорих анги бий болгох асуудлаар ШШГЕГ, хорих 401, хорих 407-р ангийн удирдлагууд, мониторинг хийсэн ТББ-ын төлөөлөлтэй уулзалт хийв.

Олон улсын хүний эрхийн өдөр:

12-р сард Хууль зүйн сургуулиудын олон улсын эрх зүйн хичээлийн агуулгад Ромын дүрмийг бүрэн дүүрэн тусгаж өгсөн эсэх асуудлыг тодорхойлох, сургалтын модулийг бэлтгэх талаар судалгаа хийв. Хууль зүйн сургуулийн багш, өмгөөлөгч, шүүгч, прокуроруудад "Олон улсын шүүх ба олон улсын эрүүгийн шүүх" сэдвээр сургалт зохион байгууллаа. ХЗДС-ын Олон улсын эрх зүйн тэнхимтэй хамтран шүүгч нарт ОУЭШ-ийн асуудлаар илтгэл тавив.



ГОЛ АМЖИЛТ, ҮР ДҮН

- Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд нэгдэн орох асуудлаарх лобби уулзалт холбогдох төрийн албан тушаалтнуудыг хамруулж, асуудлыг хүргэлээ. Хэлэлцүүлэгт ТЕГ, ШШГЕГ, Цагдаа мөрдөн байцаах, Прокурор, Шүүх, Өмгөөлөлийн байгууллагын нийт 60 гаруй хүн оролцов.
- Эрүүдэн шүүхийн хохирогчдод туслах ОУ-ын өдөрт Францын элчин сайд, НҮБ-ын суурин төлөөлөгчийн төлөөлөгч, УЕПДМБА, ШШГЕГ, ХЭҮК, шашны төлөөлөл зэрэг гол зорилтот бүлгүүд хүрэлцэн ирж, ЭШЭКНП-д нэгдэн орохыг дэмжиж байгаагаа илэрхийлэв.





Залуучууд

Зорилго, зорилтууд

- Залуучуудыг хүний эрхийн асуудалд өргөнөөр татан оруулах, тэдний хүний эрхийн төлөөх үйл ажиллагааг дэмжих
- Хүний эрхийг орон нутгийн, үндэсний, олон улсын түвшинд хамгаалах, дэмжих эвсэл холбоо, түншлэлийг бий болгох
- Гишүүд, дэмжигчдийн оролцох боломжийг аль болох өргөжүүлэх
- Шинэ түншлэлийг бий болгож, хөгжүүлэхийн тулд сурсан зүйлээ хуваалцах, сонголтын шалгуур, шилдэг дадлага, эрсдэлийн үнэлгээ, брэнд удирдлага зэрэг цогц арга хэрэгслийг боловсруулах

Өөрчлөлт хийхийг хүссэн залуучууд бүс нутаг, орон нутгийн хэмжээнд тулгамдаж байгаа асуудлаараа үйл ажиллагаа санаачлан, залуу идэвхитэн, гишүүд, дэмжигчдийг хамруулсан кампанит ажил өрнүүлж, олон улсын болон үндэсний түвшинд хүний эрхийг хамгаалахад өөрсдийн хувь нэмрээ оруулж байдаг билээ.

Гишүүд сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, тэмцээн

- Монголын хүүхэд, залууст хүний эрхийн боловсрол олгох, хүний эрхийг хамгаалах үйлсэд тэдний оролцоог хөхиүлэн дэмжсэн "Хүний эрхийг хангах амлалтаа биелүүлэх нь" сургалтын гарын авлага боловсрууллаа.
- "Хөгжлийн төлөө Австралийн залуу элч нар" залуучуудын сайн дурын хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Монголын Эмнести Интернэшнлийн гишүүн 30 сургагч багш бэлтгэгдэв. Залуу сургагч багш нар Дархан-Уул аймгийн залуу багш, сурагчдад зориулсан Уур амьсгалын өөрчлөлт хүний эрхийг зөрчиж буй талаар "Бидний амьдрах орчин ба бидний эрх" сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Ази Номхон Далайн Бүсийн Залуучуудын Сүлжээний Залуу элч хөтөлбөр

Залуучуудын манлайллыг дэмжиж, хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Ази Номхон Далайн Бүсийн Залуучуудын Сүлжээний Залуу элч нар болон залуу идэвхтэн гишүүдийн санаачилгаар Хүний эрхийн мэтгэлцээнийг Хобби, Орчлон зэрэг сургуулийн 4 багийн дунд англи монгол хэл дээр кампанит ажлын 4 сэдвээр өрнүүлээ.

• Залуу гишүүд багаар ажиллах чадвараа хөгжүүлэх зорилгоор олон улсын харилцааны ангийн оюутнуудын дунд зохион байгуулдаг "НҮБ-ын загвар хуралдаан"-д Цагаач ажилчдын эрхийн сэдвээр оролцлоо.

Зуны сургалт

Хүний хөгжлийн суурь асуудалд хүний эрхийг дээдлэх, залуучуудын оролцоог хангах талаар үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох зорилгоор их дээд сургуулийн оюутан залуучуудын дунд илтгэлийн уралдаан зарлах, "Залуучууд - Хүний эрх - Хөгжил" чуулга уулзалт зохион байгуулав.

• Залуучуудад зориулсан хүний эрхийн сургалт, үйл ажиллагааг Шихихутаг дээд сургууль, Отгонтэнгэр их сургууль, Интерпресс хэвлэлийн үйлдвэр, Ундраа зуслан дээр зохион байгуулав.

• Олон улсын оюутны эрхийг хамгаалах өдрөөр урлагийн сургуулийн оюутнуудад зориулан хүний эрхийн сургалт зохион байгуулж, урлагаар дамжуулан хүний эрхийн боловсрол олгох зорилгоор Кино Урлагийн Дээд Сургуулийн Оюутан хөгжүүлэх төвтэй хамтран ажиллаж байна

Эрх чөлөөний парад

"Эрх чөлөөний парад 2011" олон нийтийг хамарсан үйл ажиллагааг 4 дэх жилдээ Үндэсний соёл амралтын хүрээлэнд зохион байгуулав. "Хүнийг хүнээр нь хайрлая" уриатайгаар Таны нэр төр-таны эрх, Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг таниулах үйл ажиллагаа өрнүүлэн, Никарагуа дахь охид эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах даян дэлхийн уриалгад нэгдэлээ.

ГОЛ АМЖИЛТ, ҮР ДҮН

- Залуучууд "ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ НЬ" хүний эрхийг заах сургалтын гарын авлагатай боллоо.
- Параданд 20 гаруй байгууллага хамтран, дэмжин оролцов. 2000 гаруй залуус хүний эрхийн мэдээлэл хүлээн авч, хүнийг хамгаалах үйл ажиллагаанд нэгдлээ.
- 32 залуу удирдагчийг чадавхижуулав.
- Дархан Эрдэнэт, Арханхангай, Багануур Багш нар, Чөлөөт, Оюутан, Сэтгүүлч, Залуучууд, Эмэгтэйчүүд, Эмч нарын бүлэг дэх залуу гишүүд идэвхижив.



Хүний эрхийн боловсрол



Зорилго, зорилтууд

- Гол мэргэжилтнүүдээ хүний эрхийн сургалтаар хангаж, бүх хүний эрхийг дэмждэг боловсрол эзэмших боломжийг баталгаажуулахыг Засгийн Газраас шаардах
- Сургалт, хэлэлцүүлэг, ярилцлагаар янз бүрийн салбарынханд хүрж олон талт байдлыг хангах
- Ядуу нөхцөлд буй иргэдэд хүний эрхийн сургалт явуулж, эрхээ хамгаалах чадвартай болгох, Мэдээлэл технологийн дамжуулан эрх эдлэгчид болон идэвхитнүүдийг чадавхижуулах
- Засгийн Газар, Олон Улсын ТББ болон янз бүрийн салбарт түншлэл тогтоох, тэднийг хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх үйлсэд татан оруулах

Белинда тэтгэлэг

Хүний эрхийн залуу сургагч нарт зориулсан Белинда тэтгэлэгийг жил бүр шалгаруулдаг бөгөөд тэтгэлэгийн хэмжээ 200 доллар. Монгол улсад хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулж буйг нь үнэлэн “Хүний эрхийн залуу сургагч” тэтгэлэгийг Б.Энхбаяр, М.Нандинцэцэг нарт олгов.

Хүний эрхэд ээлтэй сургууль

“Хүний Эрхэд Ээлтэй Сургууль /ХЭЭС/” хөтөлбөрт Эрдэнэт хотын Баян-өндөр цогцолбор сургууль болон Дархан хотын 19-р сургуулиуд нэгдэн орж, Хамтран ажиллах, харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурснаар энэ 2011-2012 оны хичээлийн жилд 3 сургууль Хүний Эрхэд Ээлтэй Сургууль болохоор ажиллаж байна. Багш нарт нь “Сургалтын хөтөлбөрт хүний эрхийн үзэл санааг тусгах нь”, “Хүний эрхэд ээлтэй сургууль болох нь” сургалт явуулав.

• ХЭЭС-иуд дээр Хүний эрхийг сургуулийн хамтын удирдлага, шийдвэр гаргахад уялдуулах, Сургуулийн хамт олны дунд хүний эрхэд ээлтэй харилцааг дэмжих, Хүний эрхэд ээлтэй сургалтын хөтөлбөр бий болгох, Хичээлээс гадуурхи ажил, сургуулийн орчинд хүний эрхийг холбох чиглэлээр явуулж буй үйл ажиллагааг нь дэмжиж хамтран оролцоод байна. Хүний эрхэд ээлтэй сургууль хөтөлбөр хэрэгжүүлсэн туршлагаар сонин бичгийн тусгай дугаар гарган, <http://www.humanrights-friendlyschools.mn/> цахим хуудас нээв.

• ХЭЭС байгуулахын төлөө гараа өргөцгөөе ил захидлын аянг гишүүд, ХЭБ олгож буй сургалтын үеэр өрнүүлж 950 ил захиадлыг ЕБС-ын сургуулиуд, БСШУСайд Ш.Отгонбаярт хүргүүлээ. Нийслэлийн Боловсролын газрын даргатай уулзалт хийн, ХЭЭС-ийн үзэл санааг бусад сургуулиудад түгээн дэлгэрүүлэх санаа тавьлаа.

Багш нарт зориулсан сургалт

• “Хүний эрхийг Ерөнхий боловсролын хичээлийн агуулгад нэгтгэх нь” хоёр өдрийн сургалтыг Сэлэнгэ, Төв, Ховд аймгийн албан ба албан бус боловсролын зүйч нарт явуулав.

• Хүний Эрхийн Боловсролын хөтөлбөр хэрэгжүүлсэн туршлагын дөрвөн багцыг тус бүр 1000 хувь хэвлэж, сургалтын үеэр холбогдох хүмүүст хүргэлээ.

Хуульчдад зориулсан сургалт

• Нээлттэй Нийгэм форумын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Шударгаар шүүлгэх эрх” гарын авлагыг монгол хэлнээ хөрвүүлж, хуульчид болон хүний эрхийн ажилтнуудад хүргүүлэв.

• Шүүгч, Прокурор өмгөөлөгч нарт хүний эрхийн асуудлаар хандлага өөрчлөх сургалт явуулах, кридет цаг тооцуулах асуудлаар ажиллаж, Цаазаар авах ял болон ОУЭШ-ийн талаар шүүгч, прокурор өмгөөлөгч нарт зориулсан сургалтанд кридет цаг олгов.

Залуучууд ба хүний эрхийн боловсрол

• Залуу Петр Бененсон сургалтаар нийт 20 сургагч багш бэлтгэв. Сургагч багш нар 4 багт хуваагдан ЕБС-ийн 41, 58, 107-р сургууль, Хүүхдийн хаяг тогтоох төв дээр 5-9 удаагийн сургалт зохион байгуулж, нийт 73 хүүхдийг хүний эрхийн театрийн сургалтанд хамруулж, 4 жүжиг бүтээж 25 дугаар суваг ТВ-ээр гаргав.

• Эрхүүлэй ба түүний нөхөд аян Багануур, Архангай, Эрдэнэт, Дархан, УБ хотын ЕБС-ын нийт 10 сургуулиар аялав. Мөн Өсвөрийн 333 багш бэлтгэх хөтөлбөрт оролцож, сурагчдад хүний эрхийн талаархи ойлголт өгч, дэлхийн иргэний паспорт гардуулав.

Малчдад зориулсан сургалт

Уул уурхайн үйл ажиллагааны улмаас болон алслагдсан нутагт амьдардагаас болж эрх нь зөрчигдөж буй малчдад хүний эрхийн боловсрол олгож, эрхээ хамгаалах чадвар олгох сургалтыг Архангай аймгийн Цэнхэр сумын 25 малчинд хийв.

Ажил олгогч эздэд зориулсан сургалт

Ажил олгогч эздийн холбоотой уулзалт хийн, бизнес ба хүний эрхийн сургалтын модуль гаргаж 17 компанийн 21 хүн сургалт явуулав.

ГОЛ АМЖИЛТ, ҮР ДҮН

• Орон нутгийн албан ба албан бус боловсролын 105 багш сургалтанд хамрагдав. Багш нарт кридет цаг олгогдов.

• Хүний эрхэд ээлтэй сургууль болох гэрээг 3 сургуультай байгуулан, ажиллав.
• Сургалтанд хамрагдсан Архангай аймгийн малчид, Цэнхэр сумын багийн засаг дарга, тамгийн газрын ажилтнууд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ хамгаалах хамгаалах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, тодорхой амжилтанд хүрэв.

• Өсвөрийн 300 сургагч багш ЭИ болон ХЭ талаар ойлголттой болов.
• Эрхүүлэй сургалтанд нийт 400 гаруй хүүхэд хамрагдав.
• Сургалтанд суусан нийт 143 шүүгч, прокурор, өмгөөлөгч нарт кридет цаг олгогдов.



Өсөлт, хөгжил

Зорилго, зорилтууд

- Бүлгийн үйл ажиллагааг тогтмолжуулах
- Идэвхитнүүдийг шийдвэр гаргах, төлөвлөх, үнэлэхэд оролцуулах
- Үр ашигтай идэвхи санаачлагыг дэмжих

Манлайлал, ардчилалыг бэхжүүлэх чиглэлээр

- Удирдах зөвлөл 10 удаа хуралдаж, нийт 31 шийдвэр гаргаснаас 3 нь хэрэгжих шатандаа бусад нь бүрэн биелсэн байна.
- Секцийн эрх олгох үнэлгээний баг гишүүд, дэмжигч хамтран ажиллагч нартай уулзан үнэлгээ хийн зөвлөмж гаргав.
- Бүлгийн ахлагчдын уулзалт 3 удаа болов.

Гишүүдийн чадавхи бэхжүүлэх, Бүлгийн үйл ажиллагааг тогтворжуулах

- Гишүүнийг оролцоог оноожуулах программийг туршиж дуусан, үнэлгээ хийн, Гишүүдийн бүртгэлийг шинэчлэн баталгаажуулах ажил хийгдэж байна.
- 2011 онд МЭИ байгууллагын цахим, цахим бус үйл ажиллагаа, сургалтын үеэр 259 шинэ гишүүн элсэв. Шинэ гишүүний сургалт, Кампанит ажлын талаарх сургалт семинар, хэлэлцүүлгийг 30 гаруй удаа хийн, 1900 гаруй хүн хамрагдав. Үүнээс 145 гаруй идэвхитэн, 45 хүний эрхийн сургагч багш бэлтгэгдэв. Байгууллагын тогтвортой байдал, чадавхийг бэхжүүлэхийн тулд бид олон улсын, үндэсний болон орон нутгийн 30 гаруй хурал, семинарт оролцож, сургалтанд хамрагдлаа.
- Хуульчдын бүлгийн харьяа Отгон тэнгэр клуб, Оюутны бүлгийн харьяа Нийгмийн Ажилтны Энх-Орчлон клуб, Дархан дээд сургуулийн оюутны клуб, Хэнтий болон Эрдэнэт хотын Баян-Өндөр цогцолборын багш нарын албан бус бүлгүүд тус тус байгуулагдсан байна.

Ажилтнууд ба Сайн дурынхан


- Хүний эрхийн төлөө үйлсэд үр нөлөө гаргахад сайн дурынхны мэдлэг, ур чадвар, урам зориг тун чухал ба 2011 онд сайн дурын ажилтны гэрээний дагуу 7 сайн дурын ажилтан сонгосон кампанит ажлын хүрээнд гэрээ байгуулан ажиллалаа.
- Үйл ажиллагааны бэлтгэл ажилд 100 гаруй сайн дурын ажилтан оролцож, оролцоогоороо хувь нэмэр орууллаа.

Сан арвижуулалт




- 2007 онд МЭИ-ийн сан арвижуулалтын хороо байгуулсан бөгөөд 2011 оноос уг хороо нь сан арвижуулалтын багтай болон үйл ажиллагаагаа өргөжүүллээ. Уг хороо, баг нь Гүйцэтгэх товчоо, Удирдах зөвлөл, Сайн дурын ажилтан, бүлгийн ахлагч, бүлгийн гишүүдийн төлөөлөл бүхий гишүүдтэй бөгөөд 2010-2016 оны стратеги төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.
- Эмнести Интернэшнлийн 50 жилийн ойг тохиолдуулан "Amnesty shop"-ийг байгуулж борлуулалтын орлогоо нэмэгдүүлж чадлаа.

ГОЛ АМЖИЛТ, ҮР ДҮН

- Олон Улсын Эмэгтэйчүүдийн Сүлжээнд МЭИ-ийн 3 гишүүн, Хөдөлгөөний Даяар Менежментийн багт гүйцэтгэх захирал Ази тивийг төлөөлөн ажилаж байна.
- Гишүүдийн улирлын уулзалт 4 удаа зохиогдож 190 гаруй гишүүн, гишүүдэд зориулсан ХЭ-ийн сургалтанд 200 орчим гишүүд хамрагдан, 45 гишүүн сургагч багшаар бэлтгэгдэв.
- Шинээр 259 гишүүн элсэж, нийт 2109 гишүүнтэй болов. Гишүүний оноог үнэлэх карттай болов.



2011 онд хэвлэсэн ном, товхимол, тараах материал



Санхүүгийн тайлан


Эмнести Интернэшнл Олон Улсын Хөгжлийн багаас (ОУХБ) 2011 оны үйл ажиллагаанд зориулж 146,232 ам. долларын санхүүжилтийг баталсан. Мөн онд гадаад хэл дээр хэвлэгдсэн хүний эрхийн талаархи гарын авлага болон тараах материалуудыг эх хэлнээ хөрвүүлэн гаргах зорилго бүхий Азийн хэлний хөтөлбөрийн хүрээнд 13,992 ам.долларын санхүүжилтийг олсон.

2011 онд Цаазаар авах ялын эсрэг кампанит ажил, Хүний эрхийн боловсрол болон бусад кампанит ажлуудад зориулж нийт 29566 ам. долларын тэтгэлэг, хандив, санхүүжилтыг хүний эрхийг хамгаалагч гишүүд, дэмжигчид, хамтран ажиллагч хувь хүн, компани байгууллагуудаас санхүүжүүлсэн байна. Уг санхүүжүүлэгч байгууллага, хувь хүмүүсийн жагсаалтыг арын нүүрнээс үзнэ үү.


Хүний эрхийг хамгаалагч, гишүүд, дэмжигчдийн зохион байгуулсан сан арвижуулах үйл ажиллагааны үр дүнд нийт 4,924 ам. долларын сан арвижуулаа. Гишүүдийн татвар төлөлтөөс нийт 838 ам. долларын санхүүжилтийг хийжээ.

2011 онд нийт 194,131 ам. долларыг кампанит ажил, хүний эрхийн сургалт, цалин хөлс, офиссын болон бусад зардалд тус тус зарцуулсан байна.

2011 оны санхүүжилт



2011 оны зарцуулалт (Нийт 194131 ам. доллар)



Хөндлөнгийн аудитаар баталгаажсан
2011 оны санхүүгийн хураангуй тайлан

САЛБАР: МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ	2011 оны 1 сарын 01-нээс 12 сарын 31		2011 оны 1 сарын 01-нээс 12 сарын 31	
	Төсөв		Бодит	
Санхүүжилт				
Сан арвижуулах үйл ажиллагааны орлого	49,143		35,328	
Олон улсын Хөдөлгөөнөөс олгосон санхүүжилт	146,232		239,836	
Олон улсын Хөдөлгөөнөөс олгосон санхүүжилт-Азийн хэлний хөтөлбөр	11,300		13,992	
НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН ДҮН	206,675		289,156	
Зарцуулалт				
Сан арвижуулах үйл ажиллагааны зардал	3,684		3,719	
Хурал уулзалтын зардал	12,170		7,126	
Цалин хөлс	63,083		60,679	
Оффисын зардал	31,150		29,227	
Кампанит ажил, төсөл хөтөлбөр ба сургалт	93,364		86,603	
Санхүүгийн үйл ажиллагааны зардал	3,246		6,777	
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	206,676		194,131	
Эхний үлдэгдэл				
Бэлэн мөнгө [касс ба банкин дах]	100,056.01			
Нөөц сан	21,970.00			
Урьдчилж төлсөн төлбөр	176.45			
авлага	4,465.92			
өглөг	1,153.28			
Эцсийн үлдэгдэл				
Бэлэн мөнгө [касс ба банкин дах]			192,112.72	
Нөөц сан			28,561.00	
авлага			713.25	
өглөг			847.00	



Тайланг боловсруулсан Ня-бо:
Хянасан Гүицэтгэх захирал:

Т. Ариунаа
Б. Алтантуяа

Аудит хийсэн Аудитор:



О. Чулуунбаатар /"SM аудит" ХХК/

Өгөөмөр дэмжлэг

2011 онд биднийг дэмжин тэтгэлэг олгосон, бэлэн болон бэлэн бус хандив, хамтын ажиллагаагаараа тусласан доорхи байгууллагуудад талархаж байна.

Байгууллага аж ахуйн нэгжүүд

- Нээлттэй Нийгэмлэгийн хүрээлэнгийн Будапешт дахь салбар
- Нээлттэй нийгэм форум сан ТББ
- НҮБ-ын Хүүхдийн сан
- Амьд явах эрхийг хамгаалах үндэсний нийгэмлэг
- Женева дахь Эрүүдэн шүүхээс Урьдчилан Сэргийлэх Нийгэмлэг
- Хөгжлийн төлөө Австралийн залуу элч хөтөлбөр
- Арвай бархан ХХК
- Хүслийн шийдэл ХХК
- Эйр линк ХХК
- Eco water
- PC Mall
- Хувь хүрт ХХК
- Юнител ХХК
- Студи 3
- Монголын хорих байгууллагын нөхөрлөл

Гишүүд хувь хүмүүс

- Ж. Амарсанаа
- Г.Бат-Алдар
- Ч. Болор
- Г. Жамьяан
- З.Маргад
- М. Мөнхцэцэг
- Я. Мөнхчимэг
- С. Нарангэрэл
- Н. Орчлон
- Д. Цогтбаатар
- С. Цэрэндорж
- А. Түвшинтулга
- М. Отгонбаяр
- Петер Мок